



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/63

Сүхбаатар сум

Ундны усны чанар, аюулгүй байдлыг хангуулж
ажилгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "а", 29.1.5. "в", 29.1.6 "л", Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.3, 12.1.4, Эрүүл ахуйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1-11.1.5, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-8.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2018 онд аймгийн хэмжээнд ундны усны хэрэгцээг хангагч эх үүсвэрийн барилга байгууламж нь эрүүл ахуй, стандартын шаардлага хангахгүйгээс эх үүсвэрийн эргэн тойронд хөрсний бохирдолт ихээр үүссэн нь хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлж усаар дамжих халдварт өвчин гарах эрсдэлт нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан сумдын Засаг дарга нарт доорх чиглэлээр урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллахыг үүрэг болгосугай.

а.Харьяалах нутаг дэвсгэрийнхээ хүн амыг стандартын шаардлага хангасан ундны усаар тогтвортой, хүртээмжтэй хангах арга хэмжээг авч ажиллах;

б.Хүн амын хэрэглэж байгаа ундны болон ахуйн усны чанар, аюулгүй байдалд тухайн нутаг дэвсгэрийн төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамж хариуцсан байгууллага, албан тушаалтанаар холбогдох хууль тогтоомж, Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 стандартын дагуу хяналт шинжилгээг химийн үзүүлэлтээр жилд 1, нян судлалын үзүүлэлтээр жилд 4 удаа тогтмол хийлгэх;

в.Ус хангамжийн эх үүсвэрийг хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэм хяналт тавьж ажиллах, төвлөрсөн ус хангамжийн усан санд мэргэжлийн байгууллагаар ариутгал халдваргүйтгэлийг жилд 1-2 удаа тогтмол хугацаанд хийлгүүлэх;

г.Иргэд олон нийтэд усаар дамжих халдварт өвчний талаар сургалт сурталчилгааг тогтмол хийх, гарах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хяналт тавьж ажиллах;

д.Ундны усыг хөндлөнгийн хяналт шинжилгээнд хамруулсан төлбөрийг тухайн сумын Засаг даргын Тамгын газар хариуцаж төлөх;

2.Захирамжийн хэрэгжилтийн явц, үр дүнг улирал бүрийн эхний 10 хоногт, жилийн эцсийн тайлан, мэдээг жил бүрийн 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор аймгийн Мэргэжлийн хяналтын газарт хүргүүлэхийг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар /Ж.Отгонхүү/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



ШОРГИЛ